



BAYANZURKH CONSULTING LLP

EXCELLENT COUNSELOR

АВЛИГЫН ЭСРЭГ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН"2014

2014 оны 12 сарын 05 өдөр

УДИРТГАЛ

НЭГ. УДИРТГАЛ.....	2
1.1. СУДАЛГААНЫ ҮНЭЛГЭЭНИЙ АЖЛЫН ЗОРИЛГО.....	2
1.2. СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ.....	2
1.3. СУДАЛГАА, ҮНЭЛГЭЭНИЙ БАГ.....	3
1.4. СУДАЛГАА, ҮНЭЛГЭЭНД ЗАРЦУУЛАГДСАН ХУГАЦАА.....	3
1.5. СУДАЛГАА, ҮНЭЛГЭЭНИЙ АЖЛЫН ЭХ СУРВАЛЖ.....	3
1.6. СУДАЛГАА, ҮНЭЛГЭЭНИЙ ХҮРЭЭНД ХИЙГДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГАА.....	4
ТӨРИЙН БАЙГУУЛЛАГААС АВЛИГЫН ЭСРЭГ ЯВУУЛЖ БУЙ ҮЙЛ АЖИЛЛАГААГ ҮНЭЛЭСЭН НЬ БА ИРЭХ ЖИЛ ХЭРЭГЖҮҮЛБЭЛ ЗОХИХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТОЙМ ..	5
ТӨРИЙН БАЙГУУЛЛАГА (АГЕНТЛАГ, КОМПАНИУД)-ААС АВЛИГЫН ЭСРЭГ ЯВУУЛЖ БУЙ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮНЭЛГЭЭ ..	5
АВЛИГЫН ЭСРЭГ ТӨЛӨВЛӨГӨӨ, НОТЛОХ БАРИМТАНД ХИЙСЭН ҮНЭЛГЭЭ ..	8
АВЛИГЫН ЭСРЭГ ЭРМЭЛЗЛЭЛ, ЧАРМАЙЛТЫГ ТОГТООХ ЧАНАРЫН СУДАЛГАА ..	13
ЭРХ БҮХИЙ АЛБАН ТУШААЛТАН БА ЗОРИЛТОТ БҮЛГИЙН ЯРИЛЦЛАГА, АЖИГЛАЛТ ..	15
ДҮГНЭЛТ: ТӨРИЙН БАЙГУУЛЛАГААС АВЛИГЫН ЭСРЭГ ЯВУУЛЖ БУЙ ҮЙЛ АЖИЛЛАГААНЬ БА ӨНӨӨГИЙН БАЙДАЛ, ОЙРЫН ЖИЛҮҮДЭД АВАХ АРГА ХЭМЖЭЭ ..	16
НЭГ:АВЛИГЫН ЭСРЭГ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨЛТ, ТАЙЛАГНАЛ БА ТЭДГЭЭРИЙН ӨГӨӨЖ.....	16
ХОЁР:ЦАХИМ ХУУДАС БА МЭДЭЭЛЛИЙН ИЛ ТОД БАЙДАЛ БА МЭДЭЭЛЭЛ АВАХ ЭРХИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТ ..	19
ГУРАВ:ТӨРИЙН БАЙГУУЛЛАГААС АВЛИГЫН ЭСРЭГ ЯВУУЛЖ БУЙ ҮЙЛ АЖИЛЛАГААГ ҮНЭЛЭХ АРГАЧЛАЛ БА ТҮҮНИЙ АЧ ХОЛБОГДОЛ.....	22
ХАВСРАЛТУУД	

НЭГ. УДИРТГАЛ

1.1. СУДАЛГААНЫ ҮНЭЛГЭЭНИЙ АЖЛЫН ЗОРИЛГО

Авлигатай Тэмцэх Газар¹ нь авлигын эсрэг үйл ажиллагаа, хүчин чармайлтыг үнэлэх хараат бус-бие даасан судалгааны багийг шалгаруулж ирсэн нь төрийн авлигын эсрэг арга хэмжээ, түүний үр дүнг нөлөөллөөс ангид, иргэдийн оролцоотойгоор үнэлэхийг хичээсэн шинэ дэвшилтэт хичээл зүтгэл болохыг тэмдэглэе.

Судалгаа, үнэлгээний АТГ-аас боловсруулсан “Төрийн ажлын зорилго: байгууллагын авлигын эсрэг үйл ажиллагааг үнэлэх аргачлал”-ын дагуу Засгийн газрын агентлаг (26), төрийн компани (44)-уудаас авлигын эсрэг 2014 онд авч хэрэгжүүлсэн ажил, үйл ажиллагааны гүйцэтгэлийн тайланд дүн шинжилгээ хийх, дүгнэлт, тайлан бэлтгэх

1.2. СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ

Бид, авлигын эсрэг үйл ажиллагаан дахь дор дурьдсан хүчин зүйлсийн харилцан хамаарал болоод авлигыг бууруулах, түүнээс урьдчилан сэргийлэх хүчин чармайлтын өнөөгийн байдлыг хичээнгүйлэн судалж, үнэлэв. Үүнд:

- 1.Төлөвлөгөө ба түүний үндэслэл
- 2.Төлөвлөгөөний хэрэгжилт ба авлигын эсрэг нөлөөлөл
- 3.Авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны хэтийн төлөв ба авлигын урьдчилсан таамаглал² гаргалт
- 4.Авлигын эсрэг хүчин чармайлт ба нийгмийн хүлээлт

АТГ-ын Даргын 2014 оны 11 дүгээр сарын 14-ний өдрийн 122 дугаар тушаалаар батлагдсан “Төрийн байгууллагуудын авлигын эсрэг үйл ажиллагааг үнэлэх аргачлал”-ыг удирдлага болгон ажиллав.

СУДАЛГАА, ҮНЭЛГЭЭНИЙ
АЖИЛД АШИГЛАГДСАН
СУДАЛГАА АРГА

Тоо баримт цуглуулах
Индукци, дедукцийн арга
Түүврийн арга
Ярилцлага, анкетийн арга
Харьцуулсан судалгааны арга

¹АТГ

²прогнозчлол

Судалгаа үнэлгээний ажлын хүрээнд боловсруулагдаж, дүгнэгдсэн судалгааны асуултууд:

Судалгааны асуултын нэр	Зорилго	Асуулгын тоо
Ажилтан нараас авах судалгааны асуулт	Авлигатай тэмцэх үйл ажиллагааны менежментийн үр өгөөжийг тодорхойлох	12
Магадлан баталгаажуулах судалгааны асуулт	Авлигатай тэмцэх үйл ажиллагааны менежментийн үр өгөөж дэх удирдлагын нөлөөллийг тодорхойлох	10
Компанийн удирдлагын мэдээлэл судалгааны асуулт	Компанийн засаглал ба шийдвэр гаргалт нөлөөллөөс ангид эсэхийг тодорхойлох	24
Авлигын эсрэг үйл ажиллагааны төсөв ба зарцуулалтын асуулт	Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөө ба төсөвлөгдсөн хөрөнгийн хэмжээ, түүний өгөөжийг тодорхойлох	7

1.3. СУДАЛГАА, ҮНЭЛГЭЭНИЙ БАГ

Чимэд-Очирын Баяртуул	Ерөнхий партнер, “Баянзүрх консалтинг” хуулийн фирм
Эрэндоогийн Оюунбилэг	Зөвлөх “Баянзүрх консалтинг” хуулийн фирм
Гончигжавын Мөнгөнчимэг	Партнер, “Баянзүрх консалтинг” хуулийн фирм

Судалгаа, үнэлгээний тайлан нь гагцхүү хараат бус, нөлөөллөөс ангид судалгаа, үнэлгээний багийн бүтээгдэхүүн хэмээн ойлгогдоно.

Захиалагч (АТГ)-ийн болоод оролцогч тал (агентлаг, төрийн компаниуд)-уудын байр суурийг илэрхийлээгүй болно.

1.4. СУДАЛГАА, ҮНЭЛГЭЭНД ЗАРЦУУЛАГДСАН ХУГАЦАА

Нийт хугацаа	2014 оны 11 дүгээр сарын 17-ны өдрөөс 2014 оны 12 дугаар сарын 05-ны өдөр хүртэл
Ажлын хоног	15 хоног

1.5. СУДАЛГАА, ҮНЭЛГЭЭНИЙ АЖЛЫН ЭХ СУРВАЛЖ

Засгийн газрын агентлаг (26), төрийн компани (44)-уудаас хүргүүлсэн “Авлигын эсрэг үйл ажиллагааны тайлан 2014” материал (60 гаруй багц), судалгааны асуулгын хуудас (70 байгууллага, 600 гаруй ажилтан), зорилтот бүлгийн ярилцлага (7 хуулийн этгээд, 20 гаруй ажилтан) нь судалгаа, үнэлгээний ажлын эх сурвалж болно.

1.6. СУДАЛГАА, ҮНЭЛГЭЭНИЙ ХҮРЭЭНД ХИЙГДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Дагаж мөрдөгдсөн баримт бичиг	Төрийн байгууллагуудын авлигын эсрэг үйл ажиллагааг үнэлэх аргачлал
Боловсруулсан баримт бичиг	Зохион байгуулалт, ажлын удирдамж Засгийн газрын агентлаг, төрийн компаниудын авлигын эсрэг үйл ажиллагааны 2014 оны тайлан, түүнд хамаарах нотлох баримтад хийсэн дүн шинжилгээ Цахим хуудсуудын дүн шинжилгээ
Судалгаа, шинжилгээ хийсэн баримт бичиг	Засгийн газрын агентлаг, төрийн компаниудын авлигын эсрэг үйл ажиллагааны 2014 оны төлөвлөгөө, түүний тайлан Цахим хуудсууд, түүн дэх мэдээлэл
Зорилтот бүлгийн ярилцлага, түүнд хамрагдсан хуулийн этгээд	Татварын Ерөнхий Газар Шударга өрсөлдөөн хэрэглэгчийн төлөө газар Ашигт малтмалын хэрэг эрхлэх газар МИАТ ХК Эрдэнэс Монгол ХХК Монголын төмөр зам ХК Хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээний төв
Үнэлгээ хийгдсэн талбар	Засгийн газрын агентлаг (26) Төрийн компаниуд (44)
Судалгаа, үнэлгээний ажлын тайлан	Судалгаа, үнэлгээний тайлан
Дүгнэлт, зөвлөмж, санал боловсруулалт	Авлигын эсрэг үйл ажиллагааны дүгнэлт, үнэлэгдсэн талбар ба улс орны хэмжээнд өгөх зөвлөмж, санал
Мэдээлэл хүргэх	АТГ-тай хамтран хэрэгжүүлнэ.

ТАЛАРХАЛ

Авлигын эсрэг үйл ажиллагаа, хүчин чармайлтыг үнэлэхэд ажил хэргийн гүн туслалцаа үзүүлсэн Авлигатай тэмцэх газрын Урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хэлтсийн хамт болоодтус хэлтсийн дарга, эрхэлсэн комиссар Буджавын Бат-Отгон, комиссар Лхагвасүрэнгийн Нарантуяа, комиссар Батмөнхийн Баяртөгс нарт гүнталархал илэрхийлж байна.

ТӨРИЙН БАЙГУУЛЛАГААС АВЛИГЫН ЭСРЭГ ЯВУУЛЖ БУЙ ҮЙЛ АЖИЛЛАГААГ ҮНЭЛЭСЭН НЬ БА ИРЭХ ЖИЛ ХЭРЭГЖҮҮЛБЭЛ ЗОХИХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТОЙМ

<p>ТӨРИЙН БАЙГУУЛЛАГААС АВЛИГЫН ЭСРЭГ ЯВУУЛЖ БУЙҮЙЛ АЖИЛЛАГААГ ҮНЭЛЭХ АРГАЧЛАЛЫН ЗОРИЛГО:</p>	<p>Авлигатай тэмцэх газраас төрийн үйлчилгээний хүнд суртлыг багасгах, ёс зүйтэй төрийн албыг төлөвшүүлэх, хуулиар хүлээсэн үүргээ хэрэгжүүлэхэд нь дэмжлэг тусалцаа үзүүлэх</p>
<p>ХАМАРСАН ХҮРЭЭ.</p>	<p>Агентлаг 26 Төрийн компани 44</p>
<p>ҮНЭЛГЭЭНД ХАМРАГДСАН ТАЛБАР:</p>	<ul style="list-style-type: none"> •Цахим хуудас •Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөө •Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлт, тайлан •Авлигын эсрэг эрмэлзлэл, чармайлтыг тогтоох чанарын судалгаа • Түүвэр судалгаа: Зорилтот бүлгийн ярилцлага ба ажиглалт
<p>ЭРХ ЗҮЙН ОРЧИН</p>	<ul style="list-style-type: none"> • Авлигын эсрэг хууль (2006) • Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль (2011) • Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхолыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль (2012) • Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль (2005) • Компанийн тухай хууль (2011) • Шилэн дансны тухай хууль (2014) • Мэдээллийн ил тод байдлыг хангах нийтлэг журам (ЗГ тогтоол, 2013/12/14, 411) • Компанийн засаглалын кодекс (2014)

ТӨРИЙН БАЙГУУЛЛАГА (АГЕНТЛАГ, КОМПАНИУД)-ААС АВЛИГЫН ЭСРЭГ ЯВУУЛЖ БУЙ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮНЭЛГЭЭ

Оршил: “Баянзүрх консалтинг” хуулийн фирм нь Засгийн газрын агентлаг (агентлаг), төрийн өмчит компаниуд (төрийн компаниуд)-ын авлигын эсрэг явуулж буй үйл ажиллагааг үнэлэв.

Авлигатай тэмцэх газраас төрийн үйлчилгээний хүнд суртлыг багасгах, ёс зүйтэй төрийн албыг төлөвшүүлэх, хуулиар хүлээсэн үүргээ хэрэгжүүлэхэд нь дэмжлэг тусалцаа үзүүлэх зорилгоор төрийн байгууллага, компаниудын авлигын эсрэг үйл ажиллагааг нэгэн адил шалгуур, үзүүлэлтээр хараат бус хөндлөнгийн этгээдээр гүйцэтгүүлдэг.

Энэхүү авлигын эсрэг явуулж буй үйл ажиллагааны үнэлгээ (үнэлгээ)-г төрийн байгууллагуудын авлигад өртөх магадлалын түвшинг тогтоох зорилготой хэмээн ойлгохгүй байвал зохино.

Үнэлгээ нь авлигын эсрэг олон нийтийг соён гэгээрүүлэх, авлигаас урьдчилан сэргийлэх ажиллагааны нэг болно.

Үнэлгээний дүн-оноо нь авлигаас ангид байх хүчин чармайлт, идэвхи санаачлагын илэрхийлэл бөгөөд хойшид хэрэгжүүлбэл зохих үйл ажиллагааны хэр хэмжээг тодорхойлогч тоон үзүүлэлт болохыг тэмдэглэе.

Өнгөрсөн онд үнэлгээний мөрөөр байгууллага бүр өгөгдсөн зөвлөмжийн хүрээнд тус тусдаа арга хэмжээ авсан нь сайшаалттай боловч, системийн хэмжээний авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны төлөв байдалд үзүүлэх нөлөө хүлээлтээс доогуур байна.

Ийнхүү үнэлгээний явцад системийг хамарсан соён гэгээрүүлэх, урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны хамрах хүрээ, өгөөжийг дээшлүүлэх шаардлага байгаа нь илэрсэн тул тайлант 2014 онд үнэлгээнд хамрагдсан байгууллага нэг бүрт чиглэсэн зөвлөмжөөс илүүтэй бодлогын зөвлөмжийг гаргах нь оновчтой гэж үзэж, “ирэх жилд авах”, “ойрын хугацаанд авах” арга хэмжээ хэмээн хоёр бүлэгт хувааж тайланд сийрүүлэв.

Үнэлгээ нь агентлаг ба төрийн компани гэсэн талбарт нэгэн адил үзүүлэлтээр хийгдэхийн зэрэгцээ илэрч буй учир дутагдал түгээмэл байх тул үнэлэгдсэн талбар тус бүрээр тайлагнахаас илүүтэй системийг хамарсан тайланг боловсруулсан болно.

Үнэлгээний баг нь үнэлгээ, үнэлгээний дүнд илэрсэн учир дутагдал, авах арга хэмжээний талаар нэгдсэн танилцуулга, сургалтыг хийх нь ажлын үр дүнд дорвитой нөлөөлнө гэж үзэж, энэ дэмжлэгийг үзүүлэх болно.

Төрийн компаниудын ЭБАТ-уудын компанийн засаглалын мэдлэгийн практик хэрэглээг дээшлүүлэх замаар авлигын эсрэг үйл ажиллагааны хүчин чармайлалтад нөлөөлөх боломжтой гэж үзсэн ба үүнд чиглэсэн арга хэмжээг хэрэгжүүлэхэд таатай байх болно.

Үнэлгээний тоон үзүүлэлт: Хавсралт I буюу CD 1-д агентлагууд болоод төрийн компаниудын үнэлгээг онооны ихээс бага гэсэн эрэмбээр үзүүлэв.

Хавсралт 2 буюу CD 1-д агентлагууд болоод төрийн компаниудын нэгдсэн үнэлгээг аргачлалын үзүүлэлт нэг бүрээр дэлгэрэнгүй харуулав.

Онооны дарааллаар эрэмбэлснийг авлигагүйгээс авлигатай хүртэлх жагсаалт хэмээн ойлгохгүй байвал зохино.

Учир нь АТГ-аас төрийн үйлчилгээний хүнд суртлыг багасгах, ёс зүйтэй төрийн албыг төлөвшүүлэх, хуулиар хүлээсэн үүргээ хэрэгжүүлэхэд нь дэмжлэг туслалцаа үзүүлэх зорилгоор авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөө, түүний хэрэгжилтийг үнэлж байна.

Үнэлгээнд хамрагдсан хуулийн этгээдүүд бүгд авлигын эсрэг өндөр чармайлттай байхыг эрмэлзэж байгаа хэдий ч энэ төрлийн үйл ажиллагааны менежмент нэг түвшинд бус ялгаатай байгаагаас их ба бага оноо авав.

Үнэлгээнд хамрагдсан агентлаг ба төрийн компанийн үнэлгээг эрэмбэлэн Хавсралт 3, 4-т үзүүлэв.

ХУУДАСТ ХИЙСЭН ҮНЭЛГЭЭ: Төрийн байгууллагаас авлигын эсрэг явуулж буй үйл ажиллагааг үнэлэх аргачлалын дагуу байгууллагуудын цахим хуудаст нэвтэрч, батлагдсан шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлгээг хийв.

Өмнө жилтэй харьцуулахад цахим хуудас, түүний мэдээллийн цар хүрээ, ач холбогдол сайжирсан байгааг тэмдэглэж байна.

Гэсэн хэдий ч учир дутагдал оршсоор байна. Эдгээр дутагдлыг залруулах зорилгоор ойрын хугацаанд авах арга хэмжээг тодорхойлов.

УЧИР ДУТАГДАЛ	ИРЭХ ЖИЛД АВАХ АРГА ХЭМЖЭЭ
Төрийн байгууллагын вэб сайтад тавих шаардлага (MNS6285)-ыг хэрэгжүүлэх тухай	
MNS6285 хэрэгжүүлэхгүй байна.	1.Стандартын 6.1 Зохион байгуулалт хэсэгт Хуудасны зохион байгуулалт нь бүх хуудсуудад ижил буюу агуулга болон бүрэлдэхүүнүүд жигд, нэг хэвийн байна гэсэн заалтыг хэрэгжүүлэх, 2. MNS 6285:2011 стандартыг шинэчлэхдээ уг стандартын 4.1.А цахим хуудасны агуулгын ил тод байдал байгууллагатай холбоотой мэдээллийг шинэчлэх 3. Ил тод байдлын хүрээнд компанийн хувьцаа, хувьцаа эзэмшигчид, ТУЗ, эрх бүхий албан тушаалтан нарын тухай мэдээллийг оруулах
Мэдээлэл оруулах огноо бүртгэгдэх тухай	
Зарим байгууллагуудын оруулсан мэдээлэл хэдийд оруулсан болох нь харагдахгүй байна.	Мэдээлэл оруулах стандартад огноог заавал зааж байх

Цахим хуудасны нэр оноолтын тухай	
<p>Цахим хуудасны нэр оновчгүй, монгол эсхүл англи товчлолоор нэрлэгдэж байна.</p> <p>Төрийн байгууллагууд монгол, англи гэсэн хоёр байдаар цахим хуудаст нэр оноож байна. Англи нэр оноолт нь энгийн биш, англи хэлний мэдлэгтэй хүн хүртэл товчлолыг тайлахад бэрхшээлтэй байна. Үүнийг 2008 онд хийгдсэн “Төрийн байгууллагуудын вэбсайт, мэдээллийн хүртээмжийн мониторинг” –д тэмдэглэсэн атал өдийг хүртэл өөрчлөлт гараагүйд дүн шинжилгээ хийх цаг нь болжээ.</p>	<p>Төрийн байгууллагын вэб сайтад тавих шаардлага (MNS6285)-д цахим хуудасны нэр оноох стандарт оруулах</p> <p>Төрийн байгууллагын цахим хуудсуудын хаягийн нэгтгэл бүхий лавлах цахим хуудас нээх</p>
Мэдээллийн чанар, шинэлэг байдлын тухай	
<p>Төрөөс мэдээлэл өгөх үйл ажиллагааг зохицуулсан холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг зохих ёсоор хангахгүй байна.</p>	<p>Холбогдох хууль тогтоомжийн дагуу нийтэд мэдээлэгдэж, цахим хууласт байршвал зохих бүх мэдээллийг бүрэн байршуулж, тэдгээрт хамаарах шинэчлэлтийг цаг тухад нь хийж байх,</p> <p>Авлигын эсрэг үйл ажиллагааны тухай мэдээлэл (тухайн жилийн авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөө, хэрэгжилт г.м)-ийг цахим хуудас байршуулж хэвших,</p> <p>Цахим орчин дахь авлигын эсрэг үйл ажиллагааны мэдээллийг байгууллагуудын цахим хуудаст байршуулахад аргачлалын шалгуур үзүүлэлтийг удирдлага болгон, холбогдох цонх, цэсийг эрэмбэлэх, мэдээлэл шинэчлэх хуульд заасан хугацааг баримтлах,</p>

АВЛИГЫН ЭСРЭГ ТӨЛӨВЛӨГӨӨ, НОТЛОХ БАРИМТАНД ХИЙСЭН ҮНЭЛГЭЭ

Энэхүү үнэлгээг байгууллагуудын эрх бүхий албан тушаалтан нарын ирүүлсэн тайлан, түүнд хавсаргасан нотлох баримтанд хийв.

Тайлан үнэлэхэдавлигын эсрэг үйл ажиллагааг тайлагнах стандарт, эсхүл энэ тухай зааварчилгаа байхгүйгээс тодорхой бус тайлагнал буюу аль болох их бичмэл болон хавсралт материал илгээх эрмэлзлэл өндөр байгаа нь харагдсан төдийгүй хоёрдмол утгатай үг хэллэг түгээмэл ашиглаж байгаа нь бодит байдлыг үнэлэх боломжийг сааруулж байв.

Төлөвлөсөн ажлыг бүрэн хийж гүйцэтгэсэн гэх боловч нотолгоо, баримтгүй, гүйцэтгэсэн огноо тодорхой биш зэрэг нийтлэг дутагдал оршиж байна.

Дээрхээс үзэхэд тайлангийн стандарт, эсхүл тайлагнах зааварчилгааг боловсруулж, эрх бүхий албан тушаалтан бүр төлөвлөлт-бодит байдлыг нотлох баримттайгаар хоёрдмол утга бүхий үг хэллэггүйгээр тайлагнах нь зүйтэйг анхаарна уу.

Агентлагуудын хүлээсэн үүргийн биелэлт, авлигатай тэмцэх санал санаачлага нь төрийн компаниудынхаас өндөр байгаа сайшаалтай байна.

Төрийн компаниудын хүлээсэн үүргийн биелэлтээр 70 оноо авах ёстойгоос дунджаар 39.7 оноо, авлигатай тэмцэх санал санаачлагын биелэлтээр 30 оноо авах ёстойгоос дунджаар 15.2 оноо авсан байна. Харин Агентлагуудын хувьд хүлээсэн үүргийн биелэлтээр дунджаар 50.1 оноо, Авлигатай тэмцэх санал, санаачлагын биелэлтээр дунджаар 18.5 оноо авсан байна.

Төрийн компаниудын удирдлагын томилолт, эрх хэмжээний хуваарилалт, түүний эрх зүйн зохицуулалт нь компанийн засаглалын байдалд нөлөөлжбайгааг тэмдэглэж байна.

Яам, агентлагийн ажилтан нар төрийн өмчийн төлөөлөгч, төрийн компанийн ТУЗ-ийн гишүүнээр ажиллаж байгаа нь ТУЗ-ийн хэвийн үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлж байхыг үгүйсгэхгүй.

Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой 57 компанийн ТУЗ нь 2014 оны 12 дугаар сарын байдлаар давхардсан тоогоор 474 гишүүнтэйгээс мөн

давхардсан тоогоор 176 төрийн албан хаагч ТУЗ-ийн дарга, гишүүнээр ажиллаж байна³.

Нийт үнэлгээгээр “Иргэний харьяалал, шилжилт хөдөлгөөний ерөнхий газар” хамгийн өндөр буюу 92 оноо үнэлгээ авч, өнгөрсөн онтой харьцуулахад нийт үнэлгээ 31 оноогоор өссөн байна.

Тус байгууллага нь тайлант онд “Авлигатай тэмцэх газраас бүрэн эрхийнхээ дагуу гаргасан шийдвэрийг биелүүлсэн байдал”, “Байгууллагын удирдлага авлигатай тэмцэх хүсэл эрмэлзлэл, хүчин чармайлт сайтай байсан”, “Авлигын эсрэг соён гэгээрүүлэх, авлигатай тэмцэх, урьдчилан сэргийлэх арга хэмжээг боловсруулж хэрэгжүүлэх” чиглэлд маш сайн ажилласан нь харагдаж байв.

Нийт үнэлгээгээр “Цөмийн Энергийн Газар” хамгийн их уналттай буюу өмнөх жилийнхээс 14 оноогоор буурч, 58 оноо авсан байна. Тус газрын хүлээсэн үүргийн биелэлт 46 оноо буюу харьцангуй сайн боловч авлигатай тэмцэх санал, санаачилга гаргах тал дээр маш хангалтгүй үнэлгээ авсан нь нөлөөлжээ. Энэ нь тайлант хугацааны эцэст тус газрыг татан буулгах эсэх тухай асуудал багагүй хугацаанд өрнөсөнтэй холбогдон удирдлагын эрх хэмжээ царцанги байдалд орсонтой холбоотой болохыг үгүйсгэхгүй.

Хамгийн бага буюу 44 оноогоор “Хүүхдийн төлөө үндэсний газар” үнэлэгдсэн нь 2013 оноос ердөө 2 оноогоор өсчээ. Хайнга байдалдаа дүгнэлт хийх цаг болсныг анхааруулж байна.

Агентлагууд дараахь түгээмэл оршин буй сөрөг байдлыг гойд анхаарч, залруулахыг зөвлөж байна. Үүнд:

- Шинээр боловсруулж байгаа бодлогын баримт бичиг ба нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ тогтоосон шийдвэрийн төслийг олон нийтэд танилцуулах, сонирхогч бүлгүүдтэй харилцан санал солилцох;
- Тухайн жилийн төсөвт орсон өөрчлөлтийн талаар мэдээлэх, төсвийн орлого бүрдүүлэлтийг нээлттэй болгох;

³www.mnb.mn; 2014/11/27 Төрийн өмчийн компанийн ТУЗ-д төрийн захиргааны албан хаагч ажиллахгүй

- Хууль тогтоомжийн дагуу төрийн болон байгууллагын, эсхүл хувь хүний нууцад үл хамаарахаас бусад бүртгэлийн талаарх мэдээллийг цахим хуудааст байршуулах;
- Худалдан авах ажиллагаанд хийсэн аудитын тайлан, дүгнэлт болон бусад хяналт, шалгалтын дүнг цахим хуудааст байршуулах;
- Тендерийн үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд тухайн салбарын мэргэжлийн холбоод, хувийн хэвшил, төрийн бус байгууллагын төлөөлөл оролцуулах;
- Тодорхой төрлийн үйл ажиллагааны хэрэгжилт, явц байдалд хяналт тавих, судалгаа, дүн шинжилгээ хийх ажлыг иргэний нийгмийн байгууллагаар гүйцэтгүүлэх;
- ЭБАТ-ны үйл ажиллагааг дүгнэх, ажил хэргийн туслалцаа үзүүлэх;
- Ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх буюу зөрчил үүссэн буюу үүсч болзошгүй тохиолдолд урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах;
- Ёс зүйн дүрмийн хэрэгжилтийг хамт олондоо мэдээлэж байх;
- АТГ-ын даргын 2012 оны 74 дүгээр тушаалаар батлагдсан “Албан тушаалтан өөрт ногдуулсан сахилгын шийтгэлийн талаарх мэдээллийг холбогдох этгээд болон нийтэд өөрийн зардлаар хүргэх арга хэмжээний журам”-ыг хэрэгжүүлэх;
- Төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд гарч буй хүндрэл бэрхшээл, ололт амжилт, хүрсэн үр дүн, цаашид хэрэгжүүлэх ажлын саналыг тайланд тусгасан байхад анхаарах хэрэгтэй байна.

Агентлагуудын дараахсанаачлагатай хандсанажлуудын практик өгөөжийг дээшлүүлэн ажиллавал авлигын эсрэг үйл ажиллагаанд дорвитой дэвшил гарах болно.Эдгээр нь хэдийн биелүүлбэл зохих шаардлага ч үйл авлигын эсрэг үйл ажиллагаандаа хэвшүүлсэн нь сайшаалтай байна.Үүнд:

- Зөрчлийн талаарх мэдээлэл хүлээн авах нөхцөл (тогтмол утас ажиллуулах, цахим хуудсанд байршуулах, шуудангаар эсхүл биечлэн, хайрцгаар дамжуулах г.м)-ийг бүрдүүлсэн байх;
- ЭБАТ-ыг томилох, урамшуулал өгдөг эсэх;
- Удирдлагын шийдвэрийн ил тод, нээлттэй байдлыг хангах нөхцөл, боломжийг бүрдүүлсэн байх; (цахим хуудсаар)
- Үйл ажиллагаандаа мөрдөж байгаа хууль тогтоомж (хуульчилсан акт), дүрэм, журам, зааврыг цахим хуудсандаа байршуулах;
- Хууль тогтоомжоор тогтоосон өөрийн эрхлэх асуудлын хүрээг хэвлэл, мэдээллийн хэрэгслээр нийтэд мэдээлж, сурталчилсан байх;
- Өргөдөл (санал, мэдэгдэл), гомдол, хүсэлт, мэдээлэл хүлээн авах нөхцөлийг бүрдүүлсэн байх (утас, хайрцаг, санал хүсэлтийн дэвтэр, факс, цахим, бичгээр, амаар г.м хэлбэрээр);

- Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөө баталж, хэрэгжүүлсэн байх болон төлөвлөгөөнд тусгасан арга хэмжээ цаг, хугацаандаа хэрэгжсэн байх;

Төрийн компаниудад дараах дутагдал оршиж байна. Үүнд:

- Шинээр боловсруулж байгаа бодлогын баримт бичиг ба нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ тогтоосон шийдвэрийн төслийг олон нийтэд танилцуулах, сонирхогч бүлгүүдтэй харилцан санал солилцох тал дээр дутагдалтай;
- Тухайн жилд явуулах хяналт шалгалтын ажлын төлөвлөгөө /төлөвлөгөөт/-г цахим хуудсандаа байршуулдаггүй;
- Төсвийн орлого бүрдүүлэлтийг нээлттэй болгоогүй (татварын орлого, татварын бус орлогын талаарх мэдээлэл);
- Тухайн зөвшөөрөл эзэмшигчийн нэр, хаяг, эрхлэх үйл ажиллагааны чиглэл, зөвшөөрөл олгосон болон дуусгавар болох хугацааг цахим хуудсандаа ойлгомжтой байдлаар байршуулаагүй;
- Тендерт шалгарсан болон шалгараагүй оролцогчийн талаарх мэдээлэл (шалгарсан болон шалгарч чадаагүй шалтгаан, нөхцөл, хуулийн үндэслэл)-ийг цахим хуудсанд байршуулаагүй;
- Тендер шалгаруулах явцад илэрсэн зөрчлийн талаар тухай бүр холбогдох байгууллагад мэдээлээгүй;
- Худалдан авах ажиллагаанд хийсэн аудитын тайлан, дүгнэлт болон бусад хяналт, шалгалтын дүнг цахим хуудсандаа байршуулах;
- Тодорхой төрлийн үйл ажиллагааны хэрэгжилт, явц байдалд хяналт тавих, судалгаа, дүн шинжилгээ хийх ажлыг иргэний нийгмийн байгууллагаар гүйцэтгүүлсэн байх ёстой боловч гүйцэтгүүлсэн эсэх нь тодорхой бус;
- Төрийн бус байгууллага, иргэдтэй хамтран хэрэгжүүлсэн үйл ажиллагааны үр дүнгийн талаарх мэдээллийг тайландаа тусгаагүй;
- ЭБАТ-ын үйл ажиллагааг үнэлэх буюу үнэлсэн тайлангаа тайлагнадаггүй
- Давхар ажил эрхлэлтийн талаарх судалгаатай байх, давхар ажил эрхлэх тохиолдолд зөвшөөрөл олгодог байх талаар дутагдалтай;
- Авлигад өртөх эрсдэлтэй ажил, албан тушаал, үйлчилгээний жагсаалтыг гаргах, уг жагсаалтыг гаргахдаа тодорхой судалгаа, шинжилгээнд тулгуурладаггүй;
- Төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд гарч буй хүндрэл бэрхшээл, ололт амжилт, хүрсэн үр дүн, цаашид хэрэгжүүлэх ажлын саналыг тайланд тусгадаггүй;

Төрийн компаниуд авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөө баталж, хэрэгжүүлдэг, төлөвлөгөөнд тусгасан арга хэмжээ цаг, хугацаандаа хэрэгжсэн,

хэрэгжилтийн тайланг тогтсон хугацаанд АТГ-д хүргүүлж хэвшсэн байгааг тэмдэглэж байна.

Сайшаалтын алхамын зэрэгцээ дараахь үйл ажиллагааг ирэх жилд хэрэгжүүлэхийг зөвлөж байна. Үүнд:

ТӨЛӨВЛӨГӨӨ, ХЭРЭГЖИЛТ, ХЯНАЛТ, ТАЙЛАГНАЛ	
Тайлангийн загвар батлах Тайлагнах арга зүйн зөвлөмж боловсруулах	Тайлангийн загвар боловсруулах, биелэлтийг тайлагнах нь авлигын байдал, түүний эсрэг үйл ажиллагааш бодиттой тодорхойлох боломжийг олгоно. Үнэлгээний шалгуур үзүүлэлт тус бүрээр нотлох баримт бүхий мэдээллийг тогтоосон хугацаанд байршуулахад тухай бүрт нэгтгэл нь АТГ-т хийгддэгд программ хангамж (software)-ийн даалгавар боловсруулах, энэ одоо туршилтыг хийж улмаар 2 жилийн дотор хэрэглээнд нэвтэрүүлэх, Цаасан суурьтай нотлох баримтыг байгууллагуудаас ирүүлэх асуудлаас аль болох татгалзаж, ын цахим хуудсанд байршиж тогтмол шинэчлэгдэж байх зарчмыг хэвшүүлэх, Зайлшгүй шаардлагатай тохиолдолд цаасан суурьтай нотлох баримт ирүүлэх бол баримтыг хавтаслах (нэг хавтаст байх цаасны тоо заах), товъёог хийх, ангилах (аргачлалын дарааллаар нэр өгч бүлэглэх) зэргийг хэвшүүлэх

АВЛИГЫН ЭСРЭГ ЭРМЭЛЗЛЭЛ, ЧАРМАЙЛТЫГ ТОГТООХ ЧАНАРЫН СУДАЛГАА

Үнэлгээний ажлын явцад “Авлигын эсрэг эрмэлзлэл, чармайлтыг тогтоох чанарын судалгаа” нийт 70 хуулийн этгээдийн шийдвэр гаргалтанд шууд болон дам оролцдог 700 орчим ажилтан нараас авсан болно.

Энэхүү судалгааны асуулга нь 12 бүлэгт харъяалагдах нийт 32 асуулга, давхар нягталсан 4 бүлэг асуулгатай болно.

Нийт асуулгын анкетаас хүчингүй болсон анкет 62, үнэлэгдсэн 630 гаруй.

Судалгааны дүнгийн тойм: Байгууллагууд авлигад өртөж болзошгүй ажлын байрны жагсаалтыг гаргаж, энэ тухай мэдээлж байна. Гэхдээ танай байгууллагын авлига авах замаар байгууллагаас гарах шийдвэрт нөлөөлөх боломжтой ажлын байр нэг бүрийг та мэдэхүү гэсэн асуултад “миний эрхэлж буй албан үүргийн хүрээнд мэдэх шаардлагагүй мэдээлэл байна” гэж 20 гаруй хувь нь хариулсан байгаа нь жагсаалтын практик ач холбогдолыг үнэлэх хандлага төдийлөн сайн биш байгааг харуулж байна.

Аливаа этгээд танай байгууллагын хэн нэгэнд магад таньд авлига өгөхийг хүсэхэд Та тэргүүн ээлжинд хаана хандах вэ гэсэн асуултад “хэнд ч хэлэхгүй, яагаад гэвэл энэ мэдээллийн төлөө гарч болох эрсдлээс хэн намайг хамгаалах вэ -30 хувь”, “шууд АТГ-д хэлнэ. Манай байгууллагын хэн гэдэг албан тушаалтанд энэ тухай мэдээлэл өгөх нь тодорхой биш- 35 хувь” гэж хариулжээ. Энэ авлигын тухай мэдээлэл өгөх, мэдээлэл хүлээн авах тогтолцооны тухай танин мэдүүлэх, сурталчлах нь авлигын эсрэг үйл ажиллагаанд чухал байр суурь эзлэж байгааг харуулж байна.

Нуугдмал гэмт явдалд авлига нь багагүй орон зайг эзлэхэд авлигын тухай мэдээллийг хаана өгөх, мэдээлэл өгөгчийг хамгаалах эрх зүйн зохицуулалтын сул байдал нөлөөлөхөөр байна.

Иймд авлигаас сэргийлэх, соён гэгээрүүлэх ажлын хүрээнд **АВЛИГЫН ТУХАЙ МЭДЭЭЛЭЛИЙГ ХААНА, ХЭРХЭН ӨГӨХ, , МЭДЭЭЛЭЛ ӨГӨГЧИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАМГААЛАХ ТАЛААРХ** сурталчилгааг дориун явуулахыг зөвлөж байна.

Одоогийн хамгийн түгээмэл түгээгдсэн “ТА авлигыг зогсоож чадна” гэсэн зурагт хуудас авлигыг зогсооход төр оролцохгүй юм байна гэсэн сөрөг сэтгэгдэл төрүүлж байгааг анхаарна уу. Өөрөөр хэлбэл авлигыг төр ба иргэний хамтын ажиллагаа зогсоож, төр шударга иргэнээ хамгаалах болохыг сурталчилна уу.

Сонин хэвлэл, олон нийтийн цахим хуудасны үнэ цэнэ бүхий хуудас, байршилд тодорхой хэмжээг заасан сурталчилгааг тогтмол хугацаа тутамд үнэ төлбөргүйгээр байршуулах, телевиз, радиогийн оргил цагт авлигын эсрэг сурталчилгааг мөн үнэ төлбөргүйгээр гаргах харилцааг тэдгээрийн нийгмийн хариуцлагын салшгүй хэсэг болгож, авлигын эсрэг бүх нийтийн үйл хэргийг өрнүүлэх хэрэгтэй байна.

Төлөвлөгөөг жилд нэг удаа хурал хийж танилцуулдаг хэмээн 80 гаруй хувь хариулсан байна. Техникийн боломж хүрэн хангагдсан өнөө үед төлөвлөгөөг хурлаар танилцуулахын зэрэгцээ сар, улирал бүрийн эхэнд тухайн хугацаанд

хамаарах ажлыг цахим шуудангаар илгээх, дотоод сүлжээ болон цахим хуудас, самбарт байршуулаж байх нь зүйтэй.

Төвөлөгөөнд тусгагдсан ажилд хамаарах зардлын төсөв батлагддаг эсэх тухай мэдээллийг нийт судалгаанд хамрагдсан ажилтан нарын 70 гаруй хувь нь “төсөвт тусгагдсан эсэх тухай мэдээлэл авч байгаагүй”, “байдаггүй” гэсэн тул авлигын эсрэг үйл ажиллагааны зардлыг гэмт хэрэгтэй тэмцэх үйл ажиллагааны зардалтай уялдуулан зардлын зүйл болгон төсөвт тусгах хэрэгтэй байна.

Төлөвлөгөө баталдаг, хамт олондоо танилцуулдаж хэвшсэн нь судалгаанаас харагдсан нь агентлаг, төрийн компаниудын авлигын эсрэг эрмэлзлэл төлөвшсэн болохыг харууллаа.

Харин авлигын эсрэг үйл ажиллагаан дахь удирдлагын манлайлал, түүний түвшинг тодорхойлох бие даасан “Удирдлагын манлайлал, түүнд эзлэх авлигын эсрэг үйл ажиллагааны төлөв байдал” судалгааг хийхийг зөвлөж байна.

ЭРХ БҮХИЙ АЛБАН ТУШААЛТАН БА ЗОРИЛТОТ БҮЛГИЙН ЯРИЛЦЛАГА, АЖИГЛАЛТ

-ыг Татварын Ерөнхий Газар, Шударга өрсөлдөөн хэрэглэгчийн төлөө газар, Ашигт малтмалын хэрэг эрхлэх газар, МИАТ ХК, Эрдэнэс Монгол ХХК, Монголын төмөр зам ХК, Хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээний төвд хийсэн болно.

ЭБАТ-ны нэмэгдэл хөлсний хэмжээг зорилтот бүлгийн ярилцлага хийсэн хүрээгээр харуулбал:

дд	Хуулийн этгээд	ЭБАТ-ны нэмэгдэл хөлсний хувь
1	Татварын Ерөнхий Газар	25
2	Шударга өрсөлдөөн хэрэглэгчийн төлөө газар	40
3	Ашигт малтмалын хэрэг эрхлэх газар	ЭБАТ амаржих чөлөө авсан учир мэдээлэл өгөгдөөгүй.
4	МИАТ ХК	40
5	Эрдэнэс Монгол ХХК	20
6	Монголын төмөр зам ХК	15
7	Хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээний төвд	Ажил үүргийн хуваарийн дагуу хийж гүйцэтгэдэг, ЭБАТ-аар томилсон тухай шийдвэр байхгүй тул 0 хувь

Ажилтан нь үндсэн ажил үүргийнхээ хамт ЭБАТ-аар хавсран ажиллаж, ногдсон үүргээ зохих хэмжээнд биелүүлж байгаа нь сайшаалтай байна.

Зорилтот бүлэгт хийсэн ажиглалт, ярилцлагын дүнг зөрүүтэй гаргахгүй үүднээс “Онч шийдэл” төрийн бус байгууллага, Нийгмийн бодлого, хөгжлийн судалгааны хүрээлэнгийн судлаачидтай санал солилцоход дараахь учир дутагдал түгээмэл болох нь батлагдав. Үүнд: ЭБАТ нь авлигын эсрэг үйл ажиллагааг үнэлэх арга барил сул, бодит байдал дахь өсөлт, бууралт, дэвшил ба сул байдлыг

тайлагнахаас илүүтэй аль болох их бичмэл материалыг шаардлагатай эсэхээс үл хамааран илгээх зэрэг. Үүний зэрэгцээ байгууллагын удирдлагууд авлигын эсрэг төлөвлөлт ба явцын хяналт, тайлагналыг гагцхүү ЭБАТ-ны үүрэг гэж ойлгох нь түгээмэл байгааг анхаарна уу.

Иймд ЭБАТ-д чиглэсэн бие даасан бодлогын чанартай арга хэмжээг АТГ-аас авах замаар авлигын эсрэг үйл ажиллагааны удирдлага, зохион байгуулалтад шинэтгэл хийхийг зөвлөж байна. Тухайлбал: ЭБАТ-аар ахлуулсан орон тооны бус авлигын эсрэг зөвлөл ажиллуулах, энэхүү зөвлөл нь төлөвлөгөө ба хэрэгжилтийг хариуцах гэх мэт.

ДҮГНЭЛТ: ТӨРИЙН БАЙГУУЛЛАГААС АВЛИГЫН ЭСРЭГ ЯВУУЛЖ БУЙ ҮЙЛ АЖИЛЛАГААНЬ БА ӨНӨӨГИЙН БАЙДАЛ, ОЙРЫН ЖИЛҮҮДЭД АВАХ АРГА ХЭМЖЭЭ

НЭГ:АВЛИГЫН ЭСРЭГ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨЛТ, ТАЙЛАГНАЛ БА ТЭДГЭЭРИЙН ӨГӨӨЖ

Төлөвлөлтөөс⁴ хүлээгдэж буй үр дүн:	Авлигаас урьдчилан сэргийлэх чадавхийг бэхжүүлэх, авлигаас ангид байх зан үйлийг төлөвшүүлэх, авлигын нөлөөллөөс алсгагдах нөхцөл бүрэлдүүлэх, авлигын эсрэг стратеги, хэтийн зорилгыг тодорхойлож байх
Оновчтой тайлагнал ба стратеги төлөвлөлт:	Төлөвлөлт зохистой хийгдэхийн зэрэгцээ зөв, үнэн, бодит тайлагнагдаж, тэрхүү тайлагналд тулгуурласан судалгаа, судалгаанд үндэслэсэн дараагийн төлөвлөлт гэсэн харилцан хамаарлыг хангах

Өнөөгийн байдал хандлага

Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөө(төлөвлөгөө)-г баталж, түүний хэрэгжилтийг тайлагнаж хэвшсэн нь сайшаалтай хэрэг болно.

Төрийн бүх байгууллага, компаниуд нь нэгэн адил өгөгдөл бүхий төлөвлөгөөг баталж байгаа нь эдгээр хуулийн этгээдүүд нь шинжлэх ухааны үндэстэйгээр авлигын эсрэг стратеги, хэтийн зорилгоо тодорхойлохгүй байна гэж дүгнэгдэхэд хүргэв.

⁴ Төлөвлөлт нь одоогийн байдал, хэтийн төлөв, хэтийн төлөвт хүрэх төлөвлөгөөний нэгдэл болно.

Түүнчлэн төлөвлөгөө нь хүлээгдэж буй үр дүнд хүрэхийн тулд харилцан хамааралтай, үе шаттайгаар хийгдэх ажил нэг бүрийг цаг хугацааны үргэлжлэлийн⁵ хүрээнд детальчилан заах шаардлагад нийцэхгүй байна.

Жил бүрийн дөрөвдүгээр улиралд төлөвлөгөө ба тайланд үнэлгээ хийж байгаа нь дараахь учир дутагдалтай байдлыг үүсгэжээ. Үүнд:

1. Төлөвлөгдсөн ажил төлөвлөсөн хугацаандаа хийгдсэн эсэхийг мэдэх боломжгүй байна.
2. Төлөвлөгөөний гүйцэтгэл ба үр дүнгийнпрогноз хийх нөхцлийг хязгаарлагдсан.
3. Төлөвлөгөөнд тодотгол хийж, авлигын эсрэг үйл ажиллагаанд идэвхитэй ханданзайлшгүй хийж гүйцэтгэсэн ажлыг нэмж хийсэн эсэхийг тодорхойлох нөхцөлийг хаасан.

Төлөвлөлтөд оршиж байгаа учир дутагдал нь гүйцэтгэлийн тайланд нөлөөлж, бодит байдалд гарсан үр дүн, өгөөжийг нотлох баримттайгаар тайлагнахын оронд “аль болох их” өгүүлэмж бүхий тайлан бичих, ач холбогдолгүй эсхүл огт хамааралгүй баримт бичгийг хавсарган илгээх нь түгээмэл байна.

Цахим хуудсуудад тухайн жилийн авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөний гүйцэтгэлийн тайлангбайршуулдаггүй ньтөрийн байгууллагаас авлигын эсрэг хэрэгжүүлж байгаа үйл ажиллагааны мэдээлэл хангалтгүй гэж дүгнэгдэхэд хүргэж байна.

Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардагдах мөнгөн хөрөнгийн төсвийг батлахгүй байгаагаас бусад төрлийн үйл ажиллагааны зардлаас “авах” замаар хэрэгжиж байна.

Дэмжих орчин

Авлигын эсрэг хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай 2014 оны 1 дүгээр сарын 24-ний өдрийн хуулиар “УИХ авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр батлах бөгөөд түүнийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрт заасан хугацаагаар батална⁶ гэсэн хэм хэмжээний хэрэгжилтийн хүрээнд улс орны хэмжээний “Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөлт”-д өөрчлөлт гарах эрх зүйн орчин бүрдээд байна.

⁵Тухайн төлөвлөсөн ажил хэзээ эхлээд хэзээ хүлээгдэж буй үр дүндээ хүрэх, явцын үр дүнг хэрхэн тайлагнах, хэн хийж гүйцэтгэх, хэн хариуцан тайлагнах, хянах, мэдээлэхийг тодорхой заах

⁶Авлигын эсрэг хууль, 2¹дэх заалт

Ойрын жилүүдэд авах арга хэмжээ

Улс орны хэмжээнд авлигын эсрэг стратеги төлөвлөгөө гарах, авлигын эсрэг үйл ажиллагааны хэтийн зорилгыг богино, дунд, урт хугацаанд тодорхойлох шаардлага үүссэн байгааг анхаарна уу.

Байгууллагын үйл ажиллагааны хүрээнд тогтмол хийгдэх арга хэмжээг түүний чиг үүрэгт хамруулах нь төлөвлөгөөнд тусгахаас илүү ач холбогдолтой болохыг дурьдая. Тухайлбал: Хүнд суртал, чирэгдэл учруулсан дүрэм, журмыг нягтлан үзэж, шаардлагатай тохиолдолд хүчингүй болгох ажлыг зохион байгуулах⁷ гэжээ. Харин үүнийг эрх зүйн баримт бичгүүдэд хянан нийцүүлэлт хийсэн судалгаа, түүний мөрөөр авсан арга хэмжээ хэмээн өөрчилбөл өгөөжтэй байх болно.

Авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг судалгаанд үндэслэн бодитой, үр дүнд хүрэхүйцээр төлөвлөх асуудал хэдэн он⁸ дамжин анхаарлын төвд байсаар байна.

Авлигын эсрэг төлөвлөгөөний боловсруулалт нь тухайн байгууллагын удирдлагын авлигын эсрэг эрмэлзлэлийн индикатор болно.

Иймд төлөвлөгөөг боловсруулах, хэрэгжилтэнд хяналт тавих үйл ажиллагааг байгууллагын удирдах дээд албан тушаалтаны чиг үүрэгт оруулах нь оновчтой.

Төлөвлөгдсөн үйл ажиллагаанаас хүлээж буй үр дүн, түүнд хүрэх цаг хугацаа ба шат дараалалтайгаархийгдэх арга хэмжээ нэг бүрийг тусгаж, дэлгэрэнгүй байдлаар оновчтой төлөвлөхийг зөвлөж байна.

Төлөвлөгөөний хэрэгжилтийг улирал тутам тайлагнаж хэвших нь авлигын эсрэг үйл ажиллагааны өгөөжийг дээшлүүлэх болно.

Одоогийн хэвлэмэл байдлаар тайлагнах ажиллагааг өөрчилж, Засгийн Газрын 2013 оны 411 дүгээр тогтоолоор батлагдсан “Мэдээллийн ил тод байдлыг хангах нийтлэг журам”-ын дагуу цаасан суурьтай мэдээлэл, өгөгдлийг компьютерт хөрвүүлж, цахим баримт бичиг үүсгэх зохицуулалтын хүрээнд цахим хуудастаа төлөвлөгөө, түүний хэрэгжилтийг нотлох баримтын хамт улирал бүр байршуулж хэвших нь төрөөс хэрэгжүүлж буй авлигын эсрэг үйл ажиллагааг олон

⁷Эрх зүйн хэм хэмжээ тогтоосон баримт бичиг үйлдэх бүрт хянан нийцүүлэлт хийгдэх зарчимтай.

⁸www.iaac.mn, Үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан зарим арга хэмжээний хэрэгжилтийн талаарх танилцуулга; 2009/04/27

нийтэд ил тод болгох, авлигагүй нийгмийн төлөөх итгэл үнэмшлийг хэлбэршин тогтоход чухал үүрэг гүйцэтгэнэ.

Төрийн компаниудын Төлөөлөн Удирдах Зөвлөл нь Компанийн тухай хуулийн холбогдох заалтын⁹ хүрээнд "Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөө, түүний гүйцэтгэл"-ийндүгнэлтийг улирал бүр гаргаж, хувьцаа эзэмшигч нарт танилцуулж байхыг зөвлөж байна.

Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөг, түүнийг хэрэгжүүлэхэд шаардагдах мөнгөн хөрөнгийн төсвийг хамтад нь төлөвлөж байх нь зүйтэй байна. Төсвийн зардлын зүйл ангийн хооронд "гүйж яваа" авлигын эсрэг үйл ажиллагааны төсвийг анхаарна уу¹⁰.

Судалгаа ба үнэлгээний ажлын дүнд авлигатай тэмцэх зорилго бүхий төрийн бус байгууллага, иргэдийн сайн дурын хөдөлгөөнийг дэмжих¹¹ талаар хийгдэж буй ажил бүрхэг, эсхүл энэ тухай мэдээлэл байхгүй, тодорхой бус байгаа нь авлигын эсрэг үйлсэд бүх нийтийг татан оролцуулах асуудал хангалтгүй гэж дүгнэгдэх нөхцөл болж байгааг анхаарна уу.

ХОЁР: ЦАХИМ ХУУДАС БА МЭДЭЭЛЛИЙН ИЛ ТОД БАЙДАЛ БА МЭДЭЭЛЭЛ АВАХ ЭРХИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТ

Цахим хуудас, түүн дэх мэдээллийн үр өгөөж:

Төрийн үйл ажиллагааны ил тод байдал болон иргэн, хуулийн этгээдийн мэдээлэл хайх, хүлээн авах эрхийг хангахтай холбогдсон харилцааг зохицуулахад Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн зорилт оршино¹².

⁹6.1.11.компанийн жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаар дүгнэлт гаргаж, түүнийг хувьцаа эзэмшигчдийн хуралд танилцуулж батлуулах

¹⁰Судалгаанд хамрагдсан нийт төрийн албан хаагчид авлигын эсрэг үйл ажиллагааны зардлын талаар мэдэхгүй хэмээн хариулсан болно.

¹¹Авлигын эсрэг хууль, 6.1.13

¹²Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн 1.1.

Цахим хуудас¹³ гэж нийтэд нээлттэй байдлаар интернэт сүлжээнд байрлуулсан цахим баримт бичиг, мэдээллийг хэлнэ.

Цахим хуудас нь хэрэглэхэд хялбар¹⁴бөгөөд төрийн байгууллагын цахим хуудсуудтай холбоостой байвал мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн хэрэгжилт хангагдах нэгэн нөхцөл хангагдана.

Өнөөгийн байдал хандлага

Цахим хуудаст мэдээллийн шинэтгэл хийх, архив үүсгэх, хайлт хийх боломжтой болгосон¹⁵ нь энэ жилийн ололтуудын нэг байлаа.

Дараах¹⁶ дутагдал цөөнгүй тохиолдолд давтагдаж байна. Үүнд: Цахим хуудаст мэдээлэл байршуулсан огноо нь харагдахгүй, тогтмол шинэчлэх шаардлагыг биелүүлээгүй,¹⁷төрийн байгууллагуудын цахим хуудсыг нэг стандарттай болгох тухай өмнө жил өгөгдсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй, нэрбүхий цонхыг цахим хуудаст байршуулсан ч огт мэдээлэл оруулаагүй, цахим хуудсуудын шийдэл ялгаатай технологи ашиглаж хийж байгаа нь олон нийтэд мэдээлэл авахад хүндрэлтэй¹⁸, цахим хуудасны ажиллагаа их, мэдээлэл олоход хялбар биш, байршвал зохих мэдээлэл байхгүй, албан ба албан бус гэсэн цахим хуудастай байгаа, цахим хуудасны хаяг оновчгүй өгөгдсөнөөс мэдээлэл хайгч этгээдэд тухайн байгууллагын цахим хуудсыг интернэтийн орчинд хайж олоход хүндрэлтэй¹⁹ зэрэг.

Дэмжих орчин

¹³Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн 4.1.2

¹⁴ User friendly

¹⁵Зарим байгууллагуудад энэ ололт хамаарахгүй болохыг анхаарна уу.

¹⁶Зарим байгууллагын хувьд гэж ойлгоно уу.

¹⁷Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль, 4.1.5.“тогтмол шинэчлэх” гэж тухайн мэдээллийг 14 хоног тутам нэгээс доошгүй удаа шинэчлэхийг;

¹⁸Зарим байгууллагын хувьд эрх зүйн баримт бичгийг татаж авсны дараа унших байдлаар шийдсэн байхад зарим нь шууд цахим хуудас дээрээ унших, харах боломжтой байдлаар шийдэж өгсөн байна

¹⁹www.namem.gov.mn, цаг уур орчины шинжилгээний газар

Төрийн үйл ажиллагааны ил тод байдал болон иргэн, хуулийн этгээдийн мэдээлэл хайх, хүлээн авах эрхийг хангах“Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль”-ийн зорилгыг хэрэгжүүлэх, интернэтийн өргөн хэрэглээ, компьютержилт нь цахим хэлбэрт мэдээллийг оруулах, нийтэд түгээх эрх зүйн болоод техникийн орчинболно.

Ойрын жилүүдэд авах арга хэмжээ

Төрийн байгууллагуудын²⁰ цахим хуудсыг хэрэглэхэд хялбар буюу цэс, цонх зөв эрэмбэлэгдсэн, тэдгээрийн оноосон нэр ба агуулга нийцсэн, байршвал зохих буюу холбогдох бусад хууль тогтоомжийн дагуу мэдээлэгдвэл зохих бүх мэдээлэл бүрэн, хайлтын системтэй, архивын сантай, шаардлагатай бусад цахим хуудастай холбоос хийгдсэн байх нь зүйтэй байна.

Аливаа цахим хуудас “амар”²¹ байх тусам мэдээллийн ил тод байдал, хүртээмж нэмэгддэг ажээ.

Төрийн байгууллагуудын цахимт хуудсуудыг аливаа этгээдийн мэдээлэл авах эрхийг хангасан бөгөөд хэрэглэхэд “амар” байлгахын тулд цахим хуудасны технологийн шийдлийг нэг болгох, мэдээлэл шинэчлэх ба архивлахад баримтлах шаардлагыг гаргаж өгөх нь зүйтэй байна.

Одоогийн нөхцөлд хэн нэгэн системийн хэмжээний буюу төрийн байгууллагуудын засаглалын бүтэц, тогтолцоо²², хүний нөөц, төсөв, санхүү, худалдан авах үйл ажиллагааны тухай мэдээлэл олохын тулд тэдгээр байгууллагуудын бүх цахим хуудаст зочлох хэрэгтэй болж байна.

Нөгөө талаас төрийн байгууллагуудын ил тод байдлыг харьцуулах, нээлттэй мониторингийн орчин бүрдүүлж, нийтийн хяналтын тогтолцоог хөхиүлэн дэмжих нь шийдвэрлэвэл зохих асуудлын нэг болжээ.

Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн 7,8,9,10²³ дугаар зүйлүүдээр зохицуулагдах ил тод байдлыг хамарсан төвлөрсөн²⁴ нэг цахим хуудсыг шинээр бий²⁵ болгохыг зөвлөж байна.

²⁰Төрийн байгууллага ба компаниуд гэж ойлгоно уу.

²¹User friendly

²²Шийдвэр гаргах эрх бүхий институцийн бүтэц

²³Үйл ажиллагааны ил тод байдал, хүний нөөцийн ил тод байдал, төсөв, санхүүгийн ил тод байдал, төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны ил тод байдал

²⁴портал

²⁵www.zasag.mn нь холбоосуудын нэгдэлийг сайн зохион байгуулсан цахим хуудас бол одоогийн зөвлөж буй цахим хуудас нь дурьдан буй өгөгдлийг хамарсан төвлөрсөн цахим хуудас болно.

Энэхүү төвлөрсөн цахим хуудаст төрийн байгууллагуудын цахим хуудас бүр холбоос хийгдсэн байх бөгөөд мэдээлэл хайгч иргэн, хуулийн этгээдийг нэг дороос мэдээлэл авах боломжийг хангасан дэвшилтэт арга хэмжээ болно.

Үүний зэрэгцээ тэрхүү нэгдсэн цахим хуудас дахь мэдээллүүд холбогдох байгууллагуудын цахимт хуудаст мөн байршсан байвал зохино.

Ажлын байргорилогч, худалдан авах үйл ажиллагааны тендерт оролцогчдын нэрс, тоо, сонгогдсон иргэн, хуулийн этгээдийн тухай мэдээллийг байршуулах нь ил тод байдлын сонгодог шаардлагыг бүрэн хангасан арга хэмжээ болно. Жил бүр улсын хэмжээнд хийгдсэн нийт худалдан авалтын төсөв, зарцуулалт, тендерт шалгарсан хуулийн этгээд нэг бүрт ногдох мөнгөн дүнг ажлын гүйцэтгэлийн хамт мэдээлэхийг зөвлөж байна. Одоо энэ байдал туйлын хангалтгүй байна.

Агентлагын удирдлага, компаниудын Төлөөлөн Удирдах Зөвлөл, Компанийн тухай хуулийн 84 дүгээр зүйлд заасан эрх бүхий албан тушаалтан нарын он цаг үл дасалдах байдлаар гаргасан ажил эрхлэлтийн түүх, тухайн албан тушаалд томилогдсон шийдвэр болоод компаниудын нийт хувьцаа, түүний төрөл, хувьцаа эзэмшигчдийн нэрс ба эзэмших хувьцааны төрөл, тоо, ТУЗ-ийн үйл ажиллагааны журам, хуралдааны тов, хэлэлцсэн асуудал, шийдвэрийг цахим хуудсаар мэдээлэх нь Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагын²⁶ төрийн өмчит байгууллагуудын компанийн засаглалын зарчимд нийцсэн алхам болно.

Судалгаагаар авлигын эсрэг төлөвлөгөөг жил бүрийн нэгдүгээр улиралд баталж, энэ тухайгаа хурал хийж мэдээлэхээс өөр бусад мэдээлэл дамжуулах эх сурвалжийг ашиглахгүй байх тул дотоод сүлжээнд байршуулах, улирал сар бүрээр төлөвлөгөөг танилцуулах нь зүйтэй.

ГУРАВ: ТӨРИЙН БАЙГУУЛЛАГААС АВЛИГЫН ЭСРЭГ ЯВУУЛЖ БУЙ ҮЙЛ АЖИЛЛАГААГ ҮНЭЛЭХ АРГАЧЛАЛ БА ТҮҮНИЙ АЧ ХОЛБОГДОЛ

²⁶ OECD

Төрийн байгууллагаас авлигын эсрэг явуулж буй үйл ажиллагааг үнэлэхийн ач холбогдол:

Авлигатай тэмцэх газар нь авлигын эсрэг олон нийтийг соён гэгээрүүлэх, авлигаас урьдчилан сэргийлэх чиг үүргийг²⁷ хэрэгжүүлж, энэ төрлийн ажлыг зохион байгуулах, уялдуулан зохицуулах, нэгдсэн хөтөлбөр боловсруулах, арга зүйн удирдлагаар хангах, хэрэгжилтэнд нь хяналт тавих²⁸ бүрэн эрхийнхээ дагуу төрийн байгууллагаас авлигын эсрэг явуулж буй үйл ажиллагааг үнэлж байна.

Өнөөгийн байдал хандлага

Авлигатай тэмцэх газрын даргын 2014 оны А/122 тоот тушаалаар Төрийн байгууллагаас авлигын эсрэг явуулж буй үйл ажиллагааг үнэлэх аргачлалыг шинэчлэн батлаад байна.

Монгол Улсын хэмжээнд авлигын эсрэг хэрэгжүүлж буй үйл ажиллагааг үр дүнтэй байлгахын учираргачлалыг улам бүр оновчтой болгохыг хичээж ажиллаж байгааг тэмдэглэж байна.

Дэмжих орчин

Авлигын эсрэг конвенци, Авлигын эсрэг хууль, Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх хууль, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх хуулиуд, тэдгээрт нийцүүлэн гаргасан эрх зүйн баримт бичгүүд хэрэгжиж, авлигаас ангид байх зан үйлийг төлөвшүүлэхээр төрөөс хүчин зүтгэл гаргаж байна.

Ойрын жилүүдэд авах арга хэмжээ

Үнэлгээг Засгийн газар ба УИХ-аас эмхлэн байгуулагддаг хуулийн этгээдүүд, төрийн компаниуд, нутгийн өөрөө удирдах байгууллага гэж 4 бүлэглэж, бүлэг тус бүрт харъяалагдах хуулийн этгээдүүдийн авлигын эсрэг үйл ажиллагааны харьцуулсан шинжилгээг хийн, системийн төлөв байдлыг тодорхойлон улс орны хэмжээнд хэрэгжүүлэх стратегийг тодорхойлох замаар

²⁷Авлигын эсрэг хууль, 15.1;

²⁸Авлигын эсрэг хууль, 18.1.1;

энэхүү үнэлгээний ажлыг улам бүр практик үр дүнтэй байлгах нь шийдвэрлэх асуудлын нэг болно.

Үүний зэрэгцээ авлигын шалтгаан нөхцөлийг илрүүлэн тогтоох, тэдгээрийг арилгах, авлигын үйлдлийг таслан зогсоох, үр дагаварыг арилгах арга хэмжээ авахдаа²⁹ үнэлгээний дүн, ойрын хугацаанд болон цаашид авах арга хэмжээний тухай зөвлөмжийг эргэцүүлэн хэлэлцэж байна уу.

Үнэлгээг зайнаас болон газар дээр³⁰ жилийн турш тасралтгүй хийх нь авлигын эсрэг эрмэлзлэл, үйл ажиллагааг эрчимжүүлэх болно. Үүнд хамаарах программ хангамжийг хэрэглээнд нэвтрүүлнэ үү.

Үнэлгээний аргачлалын үзүүлэлтийг өмнө дурьдсан 4 бүлэг тус бүрийн онцлогыг харгалзан үзэж болосвруулах нь үнэлгээний дүн, түүнд суурилантодорхойлогдох стратегид зөв нөлөө үзүүлэх юм.

Ирэх жил үнэлгээний үзүүлэлтийг боловсронгуй болгоход анхаарна уу. Тухайлбал: Үнэлгээний үзүүлэлтүүдийг яамд ба агентлаг, УИХ-аас эмхлэн байгуулагдаг байгууллага, төрийн компаниуд, нутгийн өөрөө удирдах ёсны байгууллага гэсэн 4 бүлэглэн, бүлгийн онцлогыг тусган шинэчлэх,

Аргачлалын асуулгад тодотгол хийхийн тулд дараахь хүчин зүйлийн нөлөөлөлийг анхаарна уу: Үүнд: 1/Авлигын түвшин (benchmark) тогтоох, 2/Зан үйлийн өөрчлөлтийг илтгэх шалгуур³¹,

Үнэлгээний шалгуур үзүүлэлт буюу асуулгыг1/ үндсэн шалгуур үзүүлэлт 2/тусгай шалгуур үзүүлэлт гэж ангилана уу.

Үүний зэрэгцээ байгууллага нэг бүр өөрийн үнэлгээг III улирлын сүүлийн сард хийхийг зөвлөж байна. Өөрийн үнэлгээ нь бодит байдал, сөрөг ба давуу талын шалтгаан нөхцлийг тодорхойлох, шуурхай арга хэмжээ авахад нөлөөлнө. Одоогийн практик нь тоон үзүүлэлтийн араас тэмүүлэх хандлагыг хөөрөгдөж, чанарын өсөлтийг орхигдуулах сул талтай байгааг анхаарна уу.

²⁹Авлигын эсрэг хууль, 6.1.12

³⁰ Offsite, onsite

³¹Жишээ нь: Ёс зүйн дүрмийг боловсруулж, мөрдүүлсэний үр дүнд тухайн байгууллагын хэмжээнд ёс зүйн зөрчлийн тоонд гарч байгаа өөрчлөлт, албан хаагчдын хандлагын өөрчлөлт, тусгай зөвшөөрлийн мэдээллийг ил тод болгосноор тусгай зөвшөөрөлтэй холбоотой зөрчил, авлига буурсан эсэх г.м асуудлаар судалгаа хийх, жил жилийн хандлага өөрчлөлтийг үнэлэж байх.

”БАЯНЗҮРХ КОНСАЛТИНГ” ХУУЛИЙН НӨХӨРЛӨЛ



